

Ховд аймгийн ИТХ-ын 2014 оны 10 дугаар
сарын 21-ний өдрийн ээлжит бус
хуралдааны 05 дугаар
тогтоолын хавсралт

ХОВД АЙМГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг. ҮНДЭСЛЭЛ

Ховд аймгийн ДНБ-д хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн 58,0 хувь, түүхий эд, импортын худалдаа голлосон үйлчилгээний салбар 37,0 хувийг эзэлж байгаа нь нэмүү өртөг бага шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ голлож байгааг харуулна. Аж үйлдвэр, уул уурхай, барилгын салбар Ховд аймгийн ДНБ-д 5,2 хувь буюу маш бага хувийг эзэлж байгаа нь эдийн засгийн хөгжлийн нэн тулгамдсан асуудал болж байна. Мөн аж үйлдвэрийн салбарт эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл маш бага хувийг эзэлж байна.

Ховд аймгийн эдийн засгийн бодит салбаруудыг хөгжүүлж, олон тулгуурт, төрөлжсөн ногоон эдийн засгийн бүтцийг бүрдүүлэхэд улс, орон нутгийн төсвөөс гадна хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулалтын эх үүсвэр онц шаардлагатай байна.

Ховд аймаг нь хөрөнгө оруулалтыг татах харьцангуй давуу нөхцөлтэй бөгөөд уул уурхай, барилгын материалыг үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өндөр технологид тулгуурлан мал аж ахуй, газар тариалан, байгалийн түүхий эдийг бүрэн боловсруулж экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн бүс нутаг, дэлхийн зах зээлд гаргах боломж байгаа юм.

Энэ нөхцөлд эдийн засгийн бусад салбаруудын хөгжлийг эрчимжүүлж, тэдгээрийн эдийн засагт эзлэх хувийг нэмэгдүүлэх нь нэн тэргүүний шаардлага болж байна. Үүний тулд нэмүү өртөг шингээсэн, экспортын баримжаатай, импортыг орлох үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хувийн хэвшлийн хөгжлийг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.

Логистик, санхүүгийн үйлчилгээг мөн гадаадын хөрөнгө оруулалтаар дэмжиж, олон улсын чанар стандартыг нэвтрүүлэх нь аймгийн үйлчилгээний салбарыг хөгжүүлж, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх юм.

Хөрөнгө оруулалтыг Ховд аймгийн өрсөлдөх чадвар, санхүү, менежментийн үр өгөөжийг дээшлүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, урт хугацааны хөгжлийн үндсийг тавих чухал хөшүүрэг, арга хэрэгсэл гэж үзэж байна.

Аймгийн эдийн засгийн салбаруудад тэргүүний технологи, менежмент нэвтрүүлж, ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүний чанар, стандартыг олон улсын жишиг, түвшинд ойртуулан нийцүүлэх замаар өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, экспортын хэмжээг өсгөх боломж юм.

Бизнесийн таатай орчин бүрдүүлж, дотоод, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг тэнцвэртэй нэмэгдүүлэхийн зэрэгцээ орон нутгийн аж ахуйн нэгжүүд гадаад зах зээлд гарах, санхүү, хөрөнгийн зах зээлд нэвтрэх нөхцөл бүрдүүлэх шаардлага байна.

Аймгийн бизнесийн орчин сайнгүй байна. Тухайлбал:

– **Бизнесийг эхлүүлэх** – компанийг улсын бүртгэлд бүртгэх цаг хугацаа урт, олон шат дамжлагатай, нэг хүнд ногдох ДНБ-тэй харьцуулахад компаний дүрмийн сангийн доод хэмжээ өндөр;

– **Тусгай зөвшөөрөл, лиценз** – тусгай зөвшөөрөл, лицензийг олж авах шат дамжлагын тоо, хугацаа, зардал өндөр;

– **Зээл авах** – Зээл авах, зээлжих нөхцөл таатай бус, зээлийн хугацаа богино, хүү өндөр, төрийн болон хувийн салбарын зээлийн мэдээллийн сан төлөвшөөгүй;

– **Гэрээний хэрэгжилт** – бизнесийн гэрээний хэрэгжилтийн түвшин бага, маргаан шийдвэрлэх өртөг зардал өндөр, цаг хугацаа урт;

– **Компанийг хаах** – компанийг хаах хугацаа, зардлын хэмжээг харьцангуй өндөр.

Хоёр. БОДЛОГЫН ЗОРИЛГО.

Ховд аймгийн хөрөнгө оруулалтын талаар баримтлах бодлого /цаашид “бодлого” гэх/-ын зорилго нь Монгол улсын Хөрөнгө оруулалтын тухай, Засаг

захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухайхууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд Ховд аймагт дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжиж, нутагшуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад оршино.

Гурав. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР БАРИМТЛАХ ЗАРЧИМ.

1. Талуудын хамтын ажиллагаа, харилцан ашигтай түншлэлд тулгуурлах;
2. Үйлдвэрлэлийн салбар дахь хувийн хэвшлийн оролцоог эрчимтэй нэмэгдүүлэхэд чиглэх;
3. Нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд зарцуулах хөрөнгө оруулалтыг түлхүү дэмжих;
4. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт импорт орлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
5. Тэргүүний, дэвшилтэт техник, технологи, ноу-хау бүхий үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх;
6. Эдийн засгийн үр ашиг, үр өгөөжид үндэслэх;
7. Эдийн засгийн чөлөөт өрсөлдөөний ижил нөхцлийг бүрдүүлж, үйлдвэрлэл, худалдаанд монополь байдлыг гаргуулахгүй байх;
8. Үр ашигтай дэд бүтцийг байгуулах;
9. Аймгийн хөгжлийн стратегийн тэргүүлэх чиглэл, салбаруудтай уялдсан хөрөнгө оруулалтын төсөл, санаачилгыг тэргүүн ээлжинд дэмжих;
10. Гадаадын хөрөнгө оруулалтын аймгийн хөдөлмөрийн зах зээл, байгаль орчинд үзүүлэх эерэг, сөрөг эрсдлийг тооцсон байх;
11. Байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг түлхүү дэмжих;
12. Удирдлагын манлайлал, оролцогч талуудын хяналт оролцоог хангах;

13. Орон нутгийн өмчийг нийтийн дуудлага худалдаагаар хувьчлах, менежментийг хувийн хэвшилд гэрээгээр шилжүүлэх.

Дөрөв. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛ, АРГА ХЭМЖЭЭ.

Бодлого, эрхзүйн таатай орчинг бүрдүүлэх талаар:

– Бизнес, эдийн засгийн харилцааг зохицуулахад нэн шаардлагатай байгаа, яаралтай боловсруулан гаргах, шинэчлэх дүрэм, журмуудын талаар хөрөнгө оруулагчид, төрийн болон ТББ, иргэдийн саналыг тусгаж боловсронгуй болгоно.

- ЗДТГ болон агентлагуудаас эдийн засаг, зах зээлийн зохицуулалт хийхдээ “хамгийн сүүлд төр зохицуулах” зарчим буюу зах зээл өөрөө зохицуулах механизмыг нэн түрүүнд авч үздэг байна.

- Аймгийн Засаг даргын дэргэд улс төрийн нам, иргэний байгууллага, бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн төлөөллийг оролцуулсан Хөгжлийн бодлогын зөвлөлийг ажиллуулна

Хувийн хэвшлийн байгууллагын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх боломжтой ажил үйлчилгээнд төсвийн хөрөнгө оруулалт хийхийг хязгаарласан журам гаргаж хэрэгжүүлэх замаар бизнест төрийн оролцоог багасгана.

Ховд аймгийн нутаг дэвсгэрт гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих журам гаргана.

- Татварын тогтолцоо, гааль, газрын бүртгэл, тусгай зөвшөөрөл, мэргэжлийн хяналтын журамд хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр өөрчлөлт хийнэ.

- INVESTKHOVD буюу Ховд аймаг, баруун бүсэд хөрөнгө оруулагчдын олон улсын чуулга уулзалтыг 2-3 жилд нэг удаа зохион байгуулж аймгийн хөрөнгө оруулалтын эрх зүй, зах зээл, бизнесийн орчны талаар дотоод, гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслээр бүх төрлийн судалчилгааг тогтмол явуулна.

Санхүү, татварын таатай нөхцлийг бүрдүүлэх талаар:

-Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх худалдан авалтанд үндэсний үйлдвэрлэгчид, өмнөх гэрээт ажлаа хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийг давуу эрхтэй оролцуулах нөхцлийг бүрдүүлнэ.

-Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан татварын чөлөөлөлт, хөнгөлөлтөөс гадна орон нутгийн шинж чанартай татвар, төлбөр, хураамжийг хөнгөлөх, чөлөөлөх талаар шийдвэр гаргаж хэрэгжүүлнэ.

-Түгээмэл тархацтай ашигт малтмалын татвар хураамжийг хөнгөлөх буюу чөлөөлнө.

-Өндөр технологийн болон оюуны шингэц бүхий бага оврын техник, тоног төхөөрөмжийн импортыг дэмжинэ

-Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн урт хугацаатай, бага хүүтэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ

-Оршин суугаа орчиндоо хувийн хөрөнгө оруулалт хийх иргэдийн санаачлагыг дэмжиж урамшуулах журам гаргаж мөрдүүлнэ.

-Банк, санхүүгийн зах зээлийг өргөжүүлж Хөрөнгө оруулалтын хамтын санг орон нутагт байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

-Орон нутгийн бонд гаргаж хөрөнгийн зах зээлд арилжаална.

-Аймгийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих дэд сан, Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрийг тогтмол нэмэгдүүлж санхүүгийн бүх төрлийн үйлчилгээ үзүүлнэ.

-Үнэт цаасны зах зээлийн хувийн хэвшил болон брокер дилерийн байгууллагын хүний нөөцийг чадавхижуулах хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

Бизнес дэмжлэг үзүүлэх төрийн үйлчилгээг сайжруулах талаар:

-Тусгай зөвшөөрөл, лиценз авахтай холбоотой дүрэм, журам, зааврыг цэгцлэн 50 хүртэл хувиар цөөлөх үйл ажиллагааг хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

-Тусгай зөвшөөрөл, лиценз олгоход шаардагдах баримт бичгийн бүрдүүлэлтийг цахим хэлбэрт шилжүүлэн, нэг цэг, нэг цонхны үйлчилгээнд оруулж бодлого, үйл ажиллагааг ил тод нээлттэй болгоно.

-Хуулийн этгээдийн бүртгэл, үйлчилгээний талаар төрийн холбогдох байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох цахим тогтолцоог бий болгож хуулийн этгээд үүсгэн байгуулах үйлчилгээг нэг цэгийн үйлчилгээгээр авдаг болно.

-Бизнес эхлүүлэх үйл ажиллагаа, шат дамжлага, зардал, цаг хугацааг хэмнэх зорилгоор нэг цэгийн үйлчилгээ нээж, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулж хөнгөн шуурхай болгоно.

-Бизнесийн төрөлжсөн зөвлөгөө мэдээлэл өгөх үйл ажиллагааг бүх талаар дэмжинэ.

-Компаний засаглалыг хөгжүүлэх талаар компаний удирдлага болоод хувьцаа эзэмшигчдийг энэ чиглэлээр сургах, дадлагажуулах ажлыг зохион байгуулна.

-Эд, хөрөнгийн эрхийн бүртгэлийг нэг цэгийн үйлчилгээнд шилжүүлнэ.

-Татвар, мэргэжлийн хяналт, бусад эрх бүхий байгууллагуудын шалгалтын үйл ажиллагааг ил тод, тодорхойболгож, давхардал, давтамжуудыг арилгана.

-Аймагт үйлдвэрлэсэн, нэмүү өртөг шингэсэн бүтээгдхүүнийг гадаад, дотоодын зах зээлд сурталчлах, борлуулахад дэмжлэг үзүүлнэ.

Газар, дэд бүтэц, худалдан авалт,ажиллах хүчнээр дэмжих чиглэл:

-Газрын кадастрын нэгдсэн мэдээллийн сан үүсгэж онлайн хэлбэрт шилжүүлнэ.

-Шинээр үйлдвэр барих хөрөнгө оруулагчид газрыг төлбөргүйгээр төсөл сонгон шалгаруулах хэлбэрээр олгож хамтран ажиллах гэрээ байгуулдаг болно.

-Барилга барихад зайлшгүй шаардлагатай зөвшөөрлүүдийг нэгтгэн нэг цэгийн үйлчилгээнд шилжүүлж, төрийн байгууллагуудын ажил үүргийн давхардлыг арилгана.

-Барилга орон сууц, боловсруулах үйлдвэр байгуулах бүсэд инженерийн дэд бүтцийн хангамжийг улсын төсөв, орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалтаар хамтран шийдвэрлэдэг болно.

-Төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд орон нутагт үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг нийлүүлэх бодлого гаргаж хэрэгжүүлнэ.

-Эмнэлэг, сургууль, төсөвт байгууллагын цагаан хэрэглэл, зөөлөн эд, "Гэр" төслийн гэрийн хэрэглэл, "Үдийн цай" хөтөлбөр зэргийг орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр тэргүүн ээлжинд хангах журам гаргаж хэрэгжүүлнэ.

-Ховд аймагт гаднын өндөр мэргэжилтэй ажилчдыг ажиллуулах нөхцлийг хангах зорилгоор тэдний ажиллах болон оршин суух визний асуудалд дэмжлэг үзүүлнэ.

-Аймагт үйлдвэрлэл эрхэлж, бүтээгдхүүнээ экспортод гаргаж буй үйлдвэрлэгчдэд мэргэжлийн ажилчин бэлтгэх, дадлагажуулах, давтан сургахад дэмжлэг үзүүлнэ.

Тээвэр, худалдаа, хил гааль, боомт, ложистикийн үйлчилгээг хөгжүүлэх талаар:

-Булгансум-Ховдхот-Өлгийхот-Цагаан нуурын маршрутаар авто тээврийн улс хоорондын транзит ба чингэлгийн тээвэрлэлт гүйцэтгэх зорилгоор гадаад худалдаа-тээврийн цогцолборуудыг байгуулж бүс нутгийн дэд бүтцийн сүлжээнд хамруулна.

-Гадаад худалдааг хөнгөвчлөх, олон улсын тээвэрлэлтийн сүлжээтэй нэгдэх зорилгоор гадаад худалдааны ложистикийн төвийг Ховд хот орчимд байгуулах төслийг хөрөнгө оруулагчидтай хамтран хэрэгжүүлнэ.

-Аймгийн төвд авто тээврийн зорчигч үйлчилгээний цогцолбор байгуулна.

-4С ангилалын том, дунд оврын агаарын хөлөг хүлээн авах чадалтай олон улсын статустай аэродромын өргөтгөлийг хийж, цагт 250-500 хүнд үйлчлэх хүчин чадалтай Олон улсын 4С зэрэглэлийн аэровокзал барина.

-Олон улсын зорчигч болон ачаа тээврийн онгоц хүлээн авах нөхцлийг бүрдүүлж БНХАУ, ОХУ-тай олон улсын нислэгүүдийг нээнэ.

-Хил, гаалийн бичиг баримт бүрдүүлэлтийг цахим, нэг цонхны хэлбэрт шилжүүлж худалдааг хөнгөвчилнө.

-Ярантын боомтод өргөтгөл хийж ачаа хүлээж авах, сэлгэн ачих цогцолбор байгуулж хөнгөвчилсэн нөхцлөөр хил нэвтрэх асуудлыг шийднэ.

Тав. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ.

Бодлогыг батлагдсан өдрөөс эхлэн хэрэгжүүлнэ.

Бодлогын хэрэгжилтийг аймгийн ЗДТГазар, холбогдох газар, хэлтэс, агентлаг хамтран зохион байгуулна.

Хэрэгжилтийн тайланг жил бүр гаргаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагад тайлагнана.

Зургаа. БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХҮРЭХ ҮР ДҮН, АЧ ХОЛБОГДОЛ.

1. Бодлого хэрэгжсэнээр Ховд аймагт дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах орчин, нөхцөл сайжирч, тэдгээрийг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг үе шаттай арга хэмжээний дагуу шийдвэрлэх нөхцөл бүрдэнэ.

2. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь аймгийн эдийн засгийн хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэх болно.

3. Дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулагдсан үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэл өсөхийн зэрэгцээ гадаадын зах зээлд гаргах экспортыг нэмэгдүүлнэ.

4. Шинээр байгуулагдсан, эсвэл дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар хүчин чадлаа нэмсэн үйлдвэрүүд ажлын байр шинээр бий болгож, иргэдийн орлого нэмэгдэнэ.

5. Гадаадын хөрөнгө оруулалт нь технологи дамжуулах, мэдлэг тараах гол эх үүсвэр болно.

6. Олон улсад нэртэй компаниуд Ховд аймагт үйл ажиллагаагаа явуулснаар цаашид дотоодын компаниудтай хамтарсан үйлдвэр байгуулах зэргээр орон нутгийн компаниудыг улсын болон гадаад зах зээлд гарах гарцыг бүрдүүлж өгнө.

---oOo---